



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

2025 оны 11 дүгээр сар

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025 оны 12 сарын 16
Улаанбаатар хот

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт

Тодорхойлолт*

Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километр шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

ТАНИЛЦСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.НАСАНТОГТОХ

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.БАТБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ц.НЭМЭХЖАРГАЛ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. АЧАА ТЭЭВЭР	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР	7
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР	8
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА	8
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	12
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР	10
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА	10
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ	13
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР	14
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА	14
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	20
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ	16
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ	17
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ	18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....	8
Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....	10
Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....	13
Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....	14
Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....	15
Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	16
Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	17
Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутгийн зорчигч.....	7
Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 8. Автотээврийн зорчигч.....	9
Зураг 9.Төмөр замын ачаа	10
Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	11
Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	11
Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	11
Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	11
Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.07.31.....	12
Зураг 15. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	12
Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр.....	13
Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор.....	13
Зураг 18. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	14
Зураг 19. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	14
Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	14
Зураг 21. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	15
Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	15
Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	16
Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар.....	17
Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	17
Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	18
Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	18

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2025 оны 11 дүгээр сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ²

Хүснэгт 1



№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
				11-р сар	Өссөн дүн	11-р сар	Өссөн дүн	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	9,530.9	82,591.2	9,933.9	85,013.9	2.9%
		Төмөр зам	мян.тн	4,307.4	41,866.1	5,287.7	44,312.8	5.8%
		Агаар	мян.тн	0.9	9.4	1.7	11.3	20.1%
		Нийт ачаа	мян.тн	13,839.2	124,466.7	15,223.3	129,338.0	3.9%
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	414.5	4,860.7	489.5	5,440.7	11.9%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	1,048.5	10,510.0	1,060.4	10,592.7	0.8%
		Автотээвэр	мян.тн	9,270.8	79,724.5	9,648.5	81,360.7	2.1%
		Нийт	мян.тн	10,319.3	90,234.5	10,708.9	91,953.4	1.9%
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	292.4	3,469.3	351.9	3,443.4	-0.7%
		Автотээвэр	мян.тн	260.2	2,866.7	285.4	3,653.2	27.4%
		Нийт	мян.тн	552.6	6,336.0	637.3	7,096.6	12.0%
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	2,552.0	23,026.0	3,386.0	24,836.0	7.9%
		Агаар	мян.тн	0.9	9.4	1.7	11.3	20.1%
		Нийт	мян.тн	2,553.0	23,035.4	3,387.7	24,847.3	7.9%
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	1,359.0	12,152.6	1,462.7	12,530.4	3.1%
		Төмөр зам	сая тн.км	1,817.1	19,324.6	2,188.5	20,891.8	8.1%
		Агаар	сая.тн.км	2.8	26.0	3.1	25.5	-2.0%
		Нийт	сая тн.км	3,178.9	31,503.2	3,654.3	33,447.7	6.2%
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,495.5	133,095.8	11,377.0	132,664.6	-0.3%
		Төмөр зам	мян.хүн	143.7	1,839.4	141.4	1,617.3	-12.1%
		Агаар	мян.хүн	138.3	2,007.8	158.4	2,266.8	12.9%
		Нийт зорчигч	мян.хүн	12,777.5	136,943.0	11,676.8	136,548.7	-0.3%
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	53.6	722.1	29.8	573.1	-20.6%
		Төмөр зам	мян.хүн	2.4	40.8	1.7	40.4	-0.8%
		Агаар	мян.хүн	107.1	1,621.1	124.9	1,859.5	14.7%
		Нийт	мян.хүн	163.1	2,384.0	156.5	2,473.0	3.7%
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	115.0	1,448.1	144.1	1,805.4	24.7%
		Төмөр зам	мян.хүн	141.9	1,802.8	139.7	1,576.9	-12.5%
		Агаар	мян.хүн	31.2	386.6	33.5	407.3	5.3%
		Нийт	мян.хүн	288.1	3,637.5	317.2	3,789.6	4.2%
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,326.9	130,925.6	11,203.0	130,286.1	-0.5%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	173.1	2,027.4	192.6	2,167.6	6.9%
		Төмөр зам	сая хүн.км	62.1	729.0	60.8	668.2	-8.3%
		Агаар	сая хүн.км	286.7	4,501.5	328.3	5,235.3	16.3%
		Нийт	сая хүн.км	521.9	7,257.9	581.7	8,071.1	11.2%
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	887.0	11,955.0	1,120	14,077	17.7%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	762.0	10,276.0	684	11,546	12.4%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	6,115.0	61,612.0	7,309	73,510	19.3%

² Зам, тээврийн салбарын 2025 оны 11 дүгээр сарын статистикийн мэдээг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР


Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2025 оны 11 дүгээр сард 15.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 10%-аар өссөн байна. Харин 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 11 сард нийт 129.3 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9%-аар өссөн байна.

- Автотээврээр 2025 оны 11 дүгээр сард 9.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 4.2%-аар өссөн байна. Өссөн дүнгээр автотээврээр нийт 85 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9%-аар, экспортын ачаа 81.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 2.1%-аар, импортын ачаа 3.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 27.4%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2025 оны 11 дүгээр сард нийт 5.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 22.8%-аар өсжээ. Өссөн дүнгээр нийт 44.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8%-аар өссөн. Үүнээс импортын ачаа 3.4 сая тонн болж 0.7%-аар буурсан бол дотоодын ачаа 24.8 сая тонн болж 7.9%-аар, экспортын ачаа 10.6 сая тонн 0.8%-аар, дамжин өнгөрсөн ачаа 5.4 сая тонн болж 11.9%-аар тус тус өссөн байна.
- Агаарын тээврээр 2025 оны 11 дүгээр сард 1.7 мянган тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 79.8%-аар өссөн. Оны эхнээс өссөн дүнгээр 11.3 мянган тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 20.1%-аар өссөн байна. Үүнээс олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 11.2 мянган тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 20.2%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 35 тонн болж өмнөх оны мөн үеэс 38.5%-аар тус тус өссөн байна.



Экспортоор 11 дүгээр сард 10.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 3.8%-аар өссөн байна. 2025 оны өссөн дүнгээр экспортын хэмжээ 91.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 1.9%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 10.6 сая тонн тээвэрлэсэн нь 0.8%-аар, автотээврээр 81.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 88%-ийг, төмөр зам 12%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2025 оны 11 дүгээр сард нийт 637.3 мянган тонн болж өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 15.3%-аар өссөн. Харин нийт өссөн дүнгээр 7.1 сая тонн ачаа импортлосон нь өмнөх оны мөн үеэс 12%-аар өсжээ. Үүнээс төмөр замаар 3.4 сая тонн ачаа импортлосон нь 0.7%-аар буурсан бол автотээврээр 3.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 27.4%-аар өссөн байна. Импортын тээврийн 49%-ийг төмөр замаар, 51%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/





1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2025 оны 11 дүгээр сард 11.7 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 8.6%-аар бууржээ. 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 11 сард 136.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.3%-аар буурсан үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2025 оны 11 дүгээр сард 11.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 11 дүгээр сараас 9.0%-аар буурсан байна. Өссөн дүнгээр нийт 121.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.6%-аар өсжээ. Өссөн дүнгээр нийт 132.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.3%-аар буурсан. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 130.3 сая зорчигч (-0.5%), орон нутагт 1.8 сая зорчигч (+24.7%), олон улсад 573.1 мянган зорчигч (-20.6%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замын тээврээр 2025 оны 11 дүгээр сард нийт 141.4 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 12.1%-аар буурсан. Өссөн дүнгээр нийт 1.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.1%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 40.4 мянган зорчигч зорчсон нь 0.8%-аар, орон нутагт 1.58 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.5%-аар тус тус буурсан байна.
- Агаарын тээврээр 2025 оны 11 дүгээр сард нийт 158.4 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 14.6%-аар өссөн. Өссөн дүнгээр нийт 2.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.9%-аар өссөн бол үүнээс олон улсад 1.9 сая зорчигч зорчсон нь 14.7%-аар, орон нутагт 407.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 5.3%-аар тус тус нэмэгдсэн байна. .


Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн



2025 оны эхний 11 сард олон улсад нийт 2.5 сая зорчигч (+3.7%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 1.9 сая зорчигч (+14.7%), автотээврээр 573.1 мянган зорчигч (-20.6%), төмөр замаар 40.4 мянган зорчигч (-0.8%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 75%, автотээвэр 23%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2025 оны эхний 11 сард орон нутагт нийт 3.8 сая зорчигч (+4.2%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 1.8 сая зорчигч (+24.7%), төмөр замаар 1.6 сая зорчигч (-12.5%), агаарын тээврээр 407.3 мянган зорчигч (+5.3%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 48%, төмөр зам 41%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА³

2025 оны өссөн дүнгээр авто замаар нийт 85 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9%-аар өслөө.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 2
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	бууралтын % /өссөн дүн/
Нийт ачаа	мян.тн	9,530.9	82,591.2	9,933.9	85,013.9	2.9%
Импорт	мян.тн	260.2	2,866.7	285.4	3,653.2	27.4%
Экспорт	мян.тн	9,270.8	79,724.5	9,648.5	81,360.7	2.1%
Ачаа эргэлт	сая тн.км	1,359.0	12,152.6	1,462.7	12,530.4	3.1%

2025 оны 11 дүгээр сард автотээврээр 9.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 4.2%-аар өссөн байна. Үүнээс экспортод 9.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 4.1%-аар, импортоор 285.4 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сараас 9.7%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 11 дүгээр сард 1,462.7 сая тонн км болсон нь өмнөх оны 11 дүгээр сараас 7.6%-аар өссөн байна.

Эхний 11 сарын байдлаар автотээврээр нийт 85 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9%-аар, экспортын ачаа 81.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 2.1%-аар, импортын ачаа 3.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 27.4%-аар өссөн байна. Ачаа эргэлт 12,530.4 сая тонн км болж өмнөх оны мөн үеэс 3.1%-аар өссөн байна.

2025 оны өссөн дүнгээр автотээврийн нийт ачаа тээврийн 96%-ийг экспортын ачаа, 4%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлсээр байна. /Зураг 7/

Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь




2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 3
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	бууралтын % /өссөн дүн/
Нийт зорчигч	хүн	12,495.5	133,095.8	11,377.0	132,664.6	-0.3%
Олон улсад	хүн	53.6	722.1	29.8	573.1	-20.6%
Орон нутагт	хүн	115.0	1,448.1	144.1	1,805.4	24.7%
Хот доторх нийтийн тээвэр	хүн	12,326.9	130,925.6	11,203.0	130,286.1	-0.5%
Зорчигч эргэлт	сая хүн.км	173.1	2,027.4	192.6	2,167.6	6.9%

³ “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын статистикийн мэдээ

Зураг 8. Зорчигч тээвэр



Автотээврээр 2025 оны 11 дүгээр сард 11.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 11 дүгээр сараас 9.0%-аар буурсан байна. Үүнээс орон нутагт 144.1 мянган зорчигч (+25.2%), олон улсад 29.8 мянган зорчигч (-44.3%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 11.2 сая зорчигч (-9.1%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 132.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.3%-аар буурсан. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 130.3 сая зорчигч (-0.5%), орон нутагт 1.8 сая зорчигч (+24.7%), олон улсад 573.1 мянган зорчигч (-20.6%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.7%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.0%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 8/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээврээр 2025 оны өссөн дүнгээр нийт 44.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8%-аар өслөө.


Хүснэгт 4

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % / өссөн дүн/
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
Ачаа тээвэрлэлт	мян.тн	4,307.4	41,866.1	5,287.7	44,312.8	5.8%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,956.3	30,388.3	3,076.7	30,491.1	0.3%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	330.4	2,773.8	1,455.5	7,270.8	162.1%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	433.0	3,886.9	0.0	695.7	-82.1%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	350.0	3,251.5	321.0	3,428.3	5.4%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	237.7	1,565.5	434.6	2,426.9	55.0%
Дотоодын ачаа	мян.тн	2,552.0	23,026.0	3,385.9	24,835.9	7.9%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	1,200.9	11,548.2	1,174.9	11,014.3	-4.6%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	330.4	2,773.8	1,455.5	7,270.8	162.1%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	433.0	3,886.9	0.0	695.7	-82.1%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	350.0	3,251.5	321.0	3,428.3	5.4%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	237.7	1,565.5	434.6	2,426.9	55.0%
Импорт ачаа	мян.тн	292.4	3,469.3	351.9	3,443.4	-0.7%
БНХАУ-аас	мян.тн	66.1	816.8	142.9	928.4	13.7%
ОХУ-руу	мян.тн	226.4	2,652.5	209.0	2,515.1	-5.2%
Экспорт ачаа	мян.тн	1,048.5	10,510.0	1,060.4	10,592.7	0.8%
БНХАУ-руу	мян.тн	1,029.8	10,333.6	1,046.0	10,446.5	1.1%
ОХУ-руу	мян.тн	18.6	176.4	14.4	146.1	-17.2%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	414.5	4,860.7	489.5	5,440.7	11.9%
БНХАУ-аас ОХУ-руу	мян.тн	136.3	1,506.8	177.0	1,706.5	13.3%
ОХУ-аас БНХАУ-руу	мян.тн	278.2	3,353.9	313.3	3,735.0	11.4%
Ачаа эргэлт	сая.тн-км	1,817.1	19,324.6	2,188.5	20,891.8	8.1%


Төмөр замын тээврээр 2025 оны 11 дүгээр сард нийт 5.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 22.8%-аар өсжээ. Үүнээс дотоодын ачаа 3.4 сая тонн болж өмнөх оны 11 дүгээр сараас 32.7%-аар, дамжин өнгөрсөн ачаа 489.5 мянган тонн болж 18.1%-аар, импортын ачаа 351.9 мянган тонн болж 20.3%-аар, экспортын ачаа 1.1 сая тонн болж 1.1%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 4/

2025 оны өссөн дүнгээр нийт 44.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8%-аар өссөн. Үүнээс импортын ачаа 3.4 сая тонн болж 0.7%-аар буурсан бол дотоодын ачаа 24.8 сая тонн болж 7.9%-аар, экспортын ачаа 10.6 сая тонн 0.8%-аар, дамжин өнгөрсөн ачаа 5.4 сая тонн болж 11.9%-аар тус тус өссөн байна. /Зураг 9/

Зураг 9. Төмөр замын ачаа, мян.тн




Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Эхний 11 сарын байдлаарх нийт ачаа тээврийн 30.5 сая тонн буюу 69%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 7.3 сая тонн буюу 16%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 3.4 сая тонн буюу 8%-ийн ачааг "Монголиантранс Ложистик" ХХК, 2.4 сая тонн ачаа буюу нийт ачааны 5%-ийг "Монголиантранс Лайн" ХХК, 695.7 мянган тонн буюу 2%-ийн ачааг "Тавантолгой төмөр зам" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 10/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 24.8 сая тонн буюу 56%-ийг дотоодын ачаа, 10.6 сая тонн буюу 24%-ийг экспортын ачаа, 5.4 сая тонн буюу 12%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 3.4 сая тонн буюу 8%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 11/

Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл




Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Дотоодод тээвэрлэсэн 24.8 сая тонн ачааны 11 сая тонн ачаа буюу 44%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 7.3 сая тонн буюу 29%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 3.4 сая тонн ачаа буюу 14%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 2.4 сая тонн буюу 10%-ийг "Монголиантранс Лайн" ХХК, 695.7 мянган тонн ачаа буюу 3%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 12/

2025 оны эхний 11 сарын байдлаар байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 91.3 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 21.8 мянган тонн, "МТЛожистик" ХХК нь 10.3 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 7.3 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 13/

Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар




Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.11.30



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос оруулав. 2025 оны эхний 11 сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 70.6 мянга, экспортын ачаа 31.4 мянга, дамжин өнгөрсөн ачаа 16.3 мянга, импортод дундажаар 10.2 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 14/

Зураг 15 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор




2025 оны эхний 11 сар буюу 2025.01.01-ний өдрөөс 2025.11.30-ны өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 15/

3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 5 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	143.7	1,839.4	141.4	1,617.3	-12.1%
Олон улс	мян.хүн	2.4	40.8	1.7	40.4	-0.8%
Орон нутаг	мян.хүн	141.9	1,802.8	139.7	1,576.9	-12.5%
Зорчигч эргэлт	сая хүн.км	62.1	729.0	60.8	668.2	-8.3%


2025 оны 11 дүгээр сард нийт 141.4 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 12.1%-аар буурсан. Үүнээс олон улсад 1.7 мянган зорчигч зорчсон нь 29.2%-аар, орон нутагт 139.7 мянган зорчигч зорчсон нь 1.5%-аар тус тус буурчээ.



Өссөн дүнгээр нийт 1.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.1%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 40.4 мянган зорчигч зорчсон нь 0.8%-аар, орон нутагт 1.58 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.5%-аар тус тус буурсан байна. Зорчигч эргэлт 668.2 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 8.9%-аар буурчээ.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь төмөр замын зорчигч тээврийн 98%-ийг эзэлж буй орон нутагт зорчих зорчигчдын тоо тогтмол буурч байгаатай холбоотой бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна. /Зураг 16/

Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор



2025.01.01-2025.11.30-ны өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос нэгтгэн гаргав. 2025 оны эхний 11 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.9 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 17/


БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
			11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	937.8	9,387.9	1,686.2	11,271.7	20.1%
2	олон улсад	тн	933.8	9,347.4	1,682.2	11,236.8	20.2%
3	орон нутагт	тн	4.1	25.3	4.0	35.0	38.5%
4	Нийт ачаа	тн	916.2	9,188.1	1,670.6	11,104.7	20.9%
5	олон улсад	тн	912.2	9,163.2	1,666.6	11,070.0	20.8%
6	орон нутагт	тн	4.1	24.9	4.0	34.7	39.5%
7	Нийт шуудан	тн	21.6	199.8	15.6	167.0	-16.4%
8	олон улсад	тн	21.6	199.4	15.6	166.7	-16.4%
9	орон нутагт	тн	0.0	0.4	0.0	0.3	-28.9%
10	Ачаа, шуудан эргэлт	мян.тн-км	2,761.2	25,990	3,138.2	25,471.9	-2.0%
11	олон улсад	мян.тн-км	2,758.7	25,976	3,136.2	25,451.4	-2.0%
12	орон нутагт	мян.тн-км	2.5	15	2.0	20.5	40.5%

Зураг 18. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан



Агаарын тээврээр 2025 оны 11 дүгээр сард 1.7 мянган тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 79.8%-аар өссөн.


Оны эхнээс өссөн дүнгээр 11.3 мянган тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 20.1%-аар өссөн байна. Үүнээс ачаа 11.1 мянган тонн тээвэрлэсэн нь 20.9%-аар өссөн бол шуудан 167 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.4%-аар буурсан байна. /Зураг 18/

2025 оны өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 11.2 мянган тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 20.2%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 35 тонн болж өмнөх оны мөн үеэс 38.5%-аар тус тус өссөн байна. /Зураг 19/


Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.7%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.3%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 98%-ийг ачаа эзэлж байгаа бол 2%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2025 оны өссөн дүнгээр 25.5 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 2.0%-аар бууржээ.

Зураг 19. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан



Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2025 оны эхний 11 сард нийт 2.3 сая зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 12.9%-аар өслөө.

Хүснэгт 7

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
Нийт зорчигч	хүн	138,258	2,007,752	158,407	2,266,815	12.9%
Олон улсад	хүн	107,090	1,621,120	124,948	1,859,515	14.7%
Орон нутагт	хүн	31,168	386,632	33,459	407,300	5.3%
Зорчигч эргэлт	мян.хүн км	286,655.5	4,501,472	328,272.4	5,235,333.5	16.3%
Олон улсад	мян.хүн км	266,832.3	4,258,676	308,380.3	4,993,719.6	17.3%
Орон нутагт	мян.хүн км	19,823.2	242,796	19,892.1	241,613.9	-0.5%

Зураг 21. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо




2025 оны 11 дүгээр сард агаарын тээврээр нийт 158.4 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 14.6%-аар өссөн. Үүнээс олон улсад 124.9 мянган зорчигч зорчиж 16.7%-аар, орон нутагт 33.5 мянган зорчигч зорчиж өмнөх оны 11 дүгээр сараас 7.4%-аар тус тус өссөн байна.

Өссөн дүнгээр нийт 2.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.9%-аар өссөн бол үүнээс олон улсад 1.9 сая зорчигч зорчсон нь 14.7%-аар, орон нутагт 407.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 5.3%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 7/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна./Зураг 22/

Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




Зорчигч эргэлт 2025 оны өссөн дүнгээр 5,235.3 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.3%-аар өссөн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 4,993.7 сая хүн км болж 17.3%-аар өссөн бол орон нутгийн зорчигч эргэлт 241.6 сая хүн км болж 0.5%-аар буурсан байна.

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8


№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
1	Олон улсад	107,090	1,621,120	124,948	1,859,515	14.7%
2	чиглэл Сөүл	33,138	595,667	38,893	603,576	1.3%
3	Бээжин	23,236	250,038	21,799	289,739	15.9%
4	Токио	8,360	115,653	10,810	152,509	31.9%
5	Истанбул	9,283	137,323	8,645	137,744	0.3%
6	ХонКонг	8,189	91,420	7,440	101,774	11.3%
7	Франкфурт	4,384	79,313	6,131	95,324	20.2%
8	Бусан	1,818	73,322		72,596	-1.0%
9	Хөх хот	5,368	47,174	7,417	58,407	23.8%
10	Чонжү	0	14,984		41,091	174.2%
11	Санья/Хайнань	1,546	14,469	3,258	28,541	97.3%
12	Тэгү	2,466	17,813		27,911	56.7%
13	Алмата	1,939	20,184	1,890	25,570	26.7%
14	Ордос	1,412	4,310	3,505	24,878	477.2%
15	Эрээн			4,130	20,796	-
16	Фукуок	682	19,407		19,057	-1.8%
17	Эрхүү	1,051	17,955	1,063	16,761	-6.6%
18	Бангкок	1,569	12,496	1,473	15,031	20.3%
19	Бусад	929	11,305	471	13,747	21.6%
20	Муан	0	16,475		12,540	-23.9%
21	Хайлаар/Хөлөнбуйр	0	15,362	1,406	11,851	-22.9%
22	Хо Ши Мин	0	2,101		11,068	426.8%
23	Хайкоу/Хайнань	314	4,799	784	10,306	114.8%
24	Пукет	0	7,900		9,405	19.1%
25	Бусад чиглэлд	1,406	53,466	5,833	56,795	6.2%

Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



2025 оны эхний 11 сарын байдлаар олон улсад нийт 1.9 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.7%-аар өссөн. Хамгийн их зорчигч зорчсон Сөүл чиглэлд 603.6 мянган зорчигч (+1.3%), Бээжин хотруу 289.7 мянган зорчигч (+15.9%), Токио чиглэлд 152.5 мянган зорчигч (+31.9%), Истанбул чиглэлд 137.7 мянган зорчигч (+0.3%), ХонгКонг чиглэлрүү 101.8 мянган зорчигч (+11.3%), Франкфурт чиглэлд 95.3 мянган зорчигч (+20.2%) тус тус тээвэрлэсэн байна. Харин Ордос, Хо Ши Мин, Чонжү, Хайнань чиглэлд зорчигчийн тоо эрс нэмэгдсээр байна. Дээрх графикт хамгийн их зорчигч зорчсон хотуудыг харуулав. /Зураг 23/

Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар




Олон улсад зорчсон зорчигчдын 44% буюу 826.7 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Айрчайна”-ийн нислэгээр 188.8 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 174.6 мянга, “Корейн айр”-ийн нислэгээр 142.3 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 92.7 мянга, Жэжү айр нислэгээр 86.5 мянга, Туркиш айр нислэгээр 78 мянга, Т-вей нислэгээр 71.8 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 69.4 мянга, АероК нислэгээр 30.8 мянга, Юнайтед эйрлайнс нислэгээр 17.8 мянга, Ираеро нислэгээр 15 мянган зорчигч, Айр бусан 12.7 мянган зорчигч тус тус олон улсад зорчсон байна. /Зураг 24/

4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
1	Орон нутагт зорчигч тээвэр	31,168	386,632	33,459	407,300	5.3%
2	чиглэл Оюутолгой	26,899	312,946	27,957	326,745	4.4%
3	Өлгий	1,186	12,716	1,211	20,621	62.2%
4	Ховд	1,346	15,688	1,522	17,060	8.7%
5	Мөрөн	490	13,556	629	14,771	9.0%
6	Улаангом	453	6,122	461	7,703	25.8%
7	Алтай	347	8,462	470	7,029	-16.9%
8	Даланзадгад	80	9,382	112	6,334	-32.5%
9	Улиастай	367	5,995	512	6,213	3.6%
10	Баянхонгор			585	651	-
11	Бусад чиглэлд		241		173	-28.2%


Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2025 оны 11 дүгээр сард орон нутагт нийт 33.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 7.4%-аар өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр орон нутагт нийт 407.3 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.3%-аар өссөн байна. Улаангом, Өлгий чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн хэвээр байна. /Хүснэгт 9/

Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2025 оны өссөн дүнгээр агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 60% буюу 244.8 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 24% буюу 97.9 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 16% буюу 64.4 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр, захиалгат нислэгээр 301 зорчигч, Геосан нислэгээр 22 зорчигч тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-ийн зорчигч 5.5%-аар буурсан бол “Аэро Монголиа” ХХК зорчигч 31.4%-аар, “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 21.3%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 26/

4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	2024 он		2025 он		Хүснэгт 10 Өсөлт, бууралтын %/өссөн дүн/
	11 дүгээр сар	Өссөн дүн	11 дүгээр сар	Өссөн дүн	
Нийт нислэгийн тоо	7,764	83,843	9,113	99,133	18.2%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	6,115	61,612	7,309	73,510	19.3%
Хөөрөлт, буулт	1,649	22,231	1,804	25,623	15.3%
Олон улсын хөөрөлт, буулт	887	11,955	1,120	14,077	17.7%
Орон нутгийн хөөрөлт, буулт	762	10,276	684	11,546	12.4%

2025 оны 11 дүгээр сард нийт нислэгийн тоо 9113 болж өмнөх оны 11 дүгээр сартай харьцуулахад 17.4%-аар, үүнээс олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 7309 болж 19.5%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 1120 болж 26.3%-аар болж өссөн бол орон нутгийн хөөрөлт, буултын тоо 684 болж 10.2%-аар буурсан байна.

2025 оны эхний 11 сард нийт нислэгийн тоо 99133 болж өмнөх оны мөн үеэс 18.2%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 73510 болж өмнөх оны мөн үеэс 19.3%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 14077 болж өмнөх оны мөн үеэс 17.7%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 11546 болж 12.4%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 27/

Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

